



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/02

Булган сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалт, Сум дундын 4 дүгээр шүүхийн 2015 оны 222 дугаар шүүгчийн захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Д.Эрдэнэбилэг (ГЮ77052910)-ийн Булган сум 6 дугаар баг Булган 3 дугаар гудамж 324 тоотод байршилтай 6308009797 нэгж талбар бүхий гэр, орон сууц хашааны газар зориулалтаар эзэмшиж буй 406 м2 газрын газар эзэмших эрхийг "Хаан банк" ХК-ийн ажилтан Ш.Жавзандулам (ВЮ82040906), О.Гантулга (УС96110539) нарт шилжүүлсүгэй.

2.Ш.Жавзандулам, О.Гантулга нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Булган сумын Засаг даргын 2003 оны 116 дугаар захирамжийн Д.Эрдэнэбилэгт холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

